



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

**“ГЕОДЕЗИ, УСНЫ БАРИЛГА  
БАЙГУУЛАМЖИЙН ГАЗАР”  
ОНӨААТҮГ**

Үйлдвэрийн баруун бүс, Москвагийн гудамж 75,  
20 дугаар хороо, Баянгол дүүрэг,  
Улаанбаатар хот, 16100 0198  
Утас: (976) 7017 1290, Факс: (976) 7017 4373  
Цахим хуудас: www.gubb.ub.gov.mn

᠒᠐᠒4. 02. 20 № 38

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ТШӨХ-ийн мэдээлэлд  
өөрчлөлт оруулах тухай**

Тус газраас зарласан ГУББГ-01/2024 тендерийн дугаар бүхий “Үерийн хамгаалалтын барилга байгууламж (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 9,10,11,21,22,23 дугаар хороо)” ажил гүйцэтгэх, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 32 дугаар зүйл нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулж байгаа бөгөөд тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1 дэх хэсэгт нийгмийн даатгалын шимтгэлийг тендерт оролцогч тасралтгүй төлсөн болохыг “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан шалгана гэж заасныг Нийгмийн даатгалын ерөнхий газраас мэдэгдсэн албан бичгийн дагуу цаасаар ирүүлэх болгон өөрчлөлт оруулж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн албан бичигт нийгмийн даатгалын салбарын хэмжээнд мэдээллийн нэгдсэн шинэ системийг нэвтрүүлэх, 1995-2023 онуудын өгөгдөл мэдээллийг хөрвүүлэх ажил хийгдэж байгаатай холбогдуулан 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үүссэн нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг төлсөн эсэх лавлагаа бусад холбогдох мэдээллийг харъяа Нийгмийн даатгалын газруудаас цаасаар гаргаж байгааг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн, цахим системээр мэдэгдэл гаргасан байна.

Иймд тендер оролцогчид 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд цахимаар мэдээлэл соилцох боломжгүй бөгөөд харъяа нийгмийн даатгалын газруудаас цаасаар лавлагаа гаргаж ирүүлэхийг мэдэгдэж байна.

Хавсралт 1 хуудастай

ДАРГА \_\_\_\_\_ Л.АРИУНТУЯА



3180600014



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,  
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2024.02.07 № 01/279  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН  
ДАРГА Ц.БАТЗУЛ ТАНАА

### Мэдээлэл хүргүүлэх тухай

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд мэдээллийн нэгдсэн шинэ системийг нэвтрүүлэх, 1995-2023 онуудын өгөгдөл мэдээллийг хөрвүүлэх ажил үе шаттай хийгдэж байгаатай холбогдуулан дараах мэдээллийг хүргүүлж байна. Үүнд:

1. Ажил олгогчийн шимтгэл төлөлтийн 2024 оны 01 дүгээр сарын тайлан илгээх хугацааг 02 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл сунгасан тул ажил олгогчийн болон даатгуулагчийн шимтгэл төлөлтийн мэдээлэл 2023 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар гарна.

2. Ажил олгогч байгууллагын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үүссэн нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг төлсөн эсэх лавлагаа бусад холбогдох мэдээллийг харьяа Нийгмийн даатгалын газруудаас цаасаар гаргаж байна.

3. Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэл төлөлтийн болон бусад холбогдох мэдээллийг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд цахимаар солилцох боломжгүй байна.

Иймд танай байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд өмнө нь цахимаар солилцож байсан ажил олгогч, даатгуулагчийн шимтгэл төлөлттэй холбоотой мэдээллийг 2023 оны 12 дугаар сар болон түүнээс өмнөх хугацаагаар авч, Нийгмийн даатгалын байгууллагуудаас цаасаар гаргасан лавлагаа, тодорхойлолтыг үйл ажиллагаандаа ашиглахыг хүсье.

Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг шинэ программ хангамжид хөрвүүлэх ажил бүрэн хийгдэж, шинэчилсэн системийн хэвийн ажиллагаа хангагдсанаар цахим мэдээлэл солилцох боломжтой болох бөгөөд системийн талаарх мэдээллийг тухайн хугацаанд нь хүргүүлэх болно.

Таны хамтын ажиллагаанд талархсан;

ДАРГА



Л.МӨНХЗУЛ